



2005.03.01

Улаанбаатар хот

**«Ашгийн бус хуулийн этгээдийн тухай
хууль»-ийн төслийн ажлын хэсэгт
соёл урлагийн салбараас гаргах санал, зөвлөмж**

Нээлттэй Нийгэм Форум /ННФ/ болон Монголын Урлагийн Зөвлөл /МУЗ/ хамтран «Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хууль»-ийн төслийн хэлэлцүүлэг уулзалтыг 2005 оны хоёрдугаар сарын 7-ны өдөр зохион байгуулав. Уулзалт хэлэлцүүлэгээс энэ хуулийн төсөл дээр ажиллаж байгаа ажлын хэсэгт дараах саналыг оруулж байна. Үүнд :

1. Хуулийн нэр : Холбоо, сан гэж хоёр хувааж байгаа нь нэг талаас зөв боловч нөгөө талаас сан гэсэн нэртэй ТББ, хадгаламж зээлийн хоршоо зэрэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байдаг учраас хуулийн нэрийг дахин хянах. Тухайлбал : “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хууль” гэж нэрлэх.
2. Зөвлөл : Энэхүү зөвлөлийг орон нутагт байгуулахгүйгээр одоо ажиллаж байгаа ХЗДХЯ-ны ТББ-ыг хариуцсан хэлтэсийг илүү өргөжүүлж, төрөлжүүлсэн хэлбэртэйгээр мэргэшсэн ажилтан ажиллахаар тусгах. 62.3-р заалтыг хасаж зөвлөлийн журмыг хуульд заасан төрийн захиргааны дээд байгууллагаас батлаж өгөхөөр тусгах.
3. Төрийн үүргийг тусгасан заалт оруулах. Тусгай зөвлөлийн тайланг хэн авах зэрэг Засгийн газрын хариуцлагыг тусгах.
4. Холбооны гишүүнчлэлийн талаар 28-р зүйлийн 3 дахь заалтад тусгагдсан холбооны гишүүнээс хасахад “гишүүнийг заавал биечлэн оролцуулж шийдвэрийг нэн даруй бичгээр гардуулна” гэсэн заалтыг өөрчилж, холбооны гишүүнээс хасах эрхийг Удирдах Зөвлөлийн мэдэлд байхаар тусгах.
5. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх : ТББ-ууд нь ашиг олж болох бүх үйл ажиллагааг дүрмэндээ тусгах боломжгүй учраас ашиг олж болох үйл ажиллагааг дүрмээр хязгаарлахгүй байхаар тусгаж 13.2-р заалтыг хасах эсвэл өөрчлөх.

6. 32-р зүйлийн 2-р заалтын “бүх гишүүдийн хурлын товыг гишүүн бүрт зар бичгийн хэлбэр /урилга захидал/ -ээр хүргэх” гэдэг нь олон гишүүнтэй байгууллагын хувьд хэрэгжүүлэхэд төвөгтэй учраас 32-р зүйлийн 3-тай нэгтгэж тусгах.
7. Соёл урлагийн салбар бусад ТББ-аас ялгагдах онцлог нь оюуны өмчтэй холбогддог учир “Соёлын тухай хууль” “Оюуны өмчийн тухай хууль” зэрэг холбогдох хуулиудын уялдаа холбоог анхаарч 29.1.2-р заалт, 29.4-р заалтад тусгах.
8. 34-р зүйлийн 1, 34-р зүйлийн 2-р заалтууд хоорондоо зөрчилдөж байгааг анхаарч өөрчлөх.
9. Нийгэмд үйлчилдэг статус авсан байгууллага дараа нь сайн дураараа татгалзаж болох эсэх заалтыг тусгах.
10. ТББ-ийн санхүүжилт, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдон гарах татварын асуудлыг энэ хууль өөрчлөгдсөнтэй холбогдон татварын бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулж тусгах. Тухайлбал :
 - ТББайгууллагад хандив өргөсөн бизнесийн байгууллагын хандиваас орлогын албан татвар тооцохгүй байх эсвэл хандивыг тухайн бизнесийн байгууллагын үйл ажиллагааны зардал хэлбэрээр тооцож болохоор татварын хуульд өөрчлөлт оруулах.
 - Нийгэмд үйлчилдэг ТББ-ыг дэмжих зорилгоор иргэд өөрийн ХАОАТатварын 1-2 хувийг ТББ-д хандивлах боломжийг судлаж, татварын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж тусгах.

Хүндэтгэсэн,

Ц.Ариунаа
Гүйцэтгэх захирал